



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 348

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2017 оны сүүлийн хагас жил, 2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар санхүүгийн зөрчил, дутагдал илрээгүйг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Гансүхт дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

1.1. Шалгалтын тайланд дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах, биелэлтийг 2019 оны гуравдугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

2. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэмд орлуулах нэмэлт өөрчлөлтийн төслийг 2019 оны гуравдугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000720